



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1989 оны 11
сарын 02 өдөр

дугаар 239

Улаанбаатар

хот


Шинээр цэцэрлэг нээж
ажиллуулах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ
НЬ:

1. Найрамдалын районы XIII хороололд шинээр ашиглалтад орж байгаа 330 ортой ясли цэцэрлэгийг 1989 оны 10 дугаар сарын I-нээс 129 дүгээр ясли-цэцэрлэг гэсэн дугаар өгч 24 цагаар, Налайхын районд шинээр барьсан 75 ортой цэцэрлэгийг 1989 оны II дүгээр сарын 15-наас Налайхын 7 дугаар цэцэрлэг гэсэн дугаараар 10 цагаар ажиллуулахыг Ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.

2. Шинээр ашиглалтад орж байгаа цэцэрлэгийн орон тоо, төсөв, хүнсний хэрэгцээт хуваарийг зохих нормативийн дагуу баталж санхүүжүүлэхийг төлөвлөгөө эдийн засгийн хэлтэс /н.Бат/, санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.

3. Шинээр ашиглалтад орж байгаа 129,7-р цэцэрлэгийн албан бичгийн тэмдгийг зохих журмын дагуу хийлгэхийг Ардын боловсролыг удирдах газар /н.Батмагнай/-т зөвшөөрсүгэй.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Д.АЛГИА